



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2011 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 188

Улаанбаатар хот

Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай

Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ тарифын өөрчлөлтийг харгалзан төсвийн норм, нормативыг шинэчлэх зорилгоор ТУШААХ нь:

Нэг. “Гадаад оронд болох хурал, зөвлөгөөн, уулзалт яармагт оролцох, гэрээ хэлэлцээр хийх, туршлага судлах зэрэг ажлаар гадаад оронд явагчдын гадаад албан томилолтын зам хоног, зочид буудлын зардлын хэмжээ”-г хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.

Хоёр. Гадаад албан томилолтоор явагчдад хот доторхи унааны зардлын хэмжээг тухайн хотод байх хугацааг хоногт 10 ам.доллараар тооцож олгосугай.

Гурав. Гадаад албан томилолтоор явагчид байгалийн гамшиг, албан ажлын шаардлага, эрүүл мэндийн шалтгаан, нислэг саатах зэрэг давагдашгүй хүчин зүйлийн улмаас гадаад оронд түр саатагдах, томилолтын хугацаа сунгагдах тохиолдолд байрны зардлыг үндсэн баримтаар, зам хоногийн зардлыг энэхүү тушаалын хавсралтын дагуу тооцож олгосугай.

Дөрөв. Энэхүү тушаалаар батлагдсан зардлын хэмжээг гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүд нэгэн адил мөрдсүгэй.

Тав. Зардлын хэмжээг шинэчилсэнтэй холбогдуулан гадаад албан томилолтын зардлыг энэ онд нэмэгдүүлэх боломжгүй байдлыг харгалзан гадаад албан томилолтоор явагсдын зам хоногийн тоог багасгах замаар батлагдсан төсвөөс хэтрүүлэхгүй байхыг төсвийн эрх захирагч нарт үүрэг болгосугай.

Зургаа. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Гадаад томилолтын хэмжээг шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2006 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 124 дүгээр тушаал, “Журам шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2011 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 86 дугаар тушаалын “Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ын 8 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.БАЯРЦОГТ

08 0270

Сангийн сайдын 2011 оны
09 дүгээр сарын 12-ний
өдрийн 189 дугаар тушаалын
хавсралт

Гадаад оронд болох хурал, зөвлөгөөн, уулзалт яармагт оролцох, гэрээ хэлэлцээр
хийх, туршлага судлах зэрэг ажлаар гадаад оронд явагчдын гадаад албан
томилолтын зам хоног, зочид буудлын зардлын хэмжээ

/АНУ-ын доллар/

Улсын нэр	Зочид буудал	Зам хоног (хоол)	Нийт
1. Баруун европын орнууд			
Австри	160	50	210
Бельги	160	50	210
Голланд	160	50	210
Герман	160	50	210
Дани	160	50	210
Испани	160	50	210
Итали	160	50	210
Ирланд	160	50	210
Их Британи	200	60	260
Норвеги	200	60	260
Португали	150	50	200
Финлянди	150	50	200
Франц	200	60	260
Швейцари	200	60	260
Швед	160	50	210
2. Зүүн европын орнууд			
Албани	100	40	140
Болгар	100	40	140
ОХУ	150	60	210
Польш	100	40	140
Румын	100	40	140
Словак	100	40	140
Серби	100	40	140
Турк	100	40	140
Унгар	100	40	140
Чех	100	40	140
Монтенегро	100	40	140
3. Хойд Америк			
АНУ	200	60	260
Канад	160	50	210

4. Латин Америк			
Аргентин	120	40	160
Бразил	120	40	160
Куба	80	40	120
Мексик	120	40	160
Перу	80	40	120
5. Ази номхон далайн орнууд			
Шинэ Зеланд	120	40	160
Австрали	200	60	260
Гвиней	80	40	120
Индонез	80	40	120
6. Азийн өндөр хөгжилтэй орнууд			
Малайз	150	50	200
Өмнөд Солонгос	150	50	200
Сингапур	150	50	200
Тайланд	100	40	140
Филлиппин	100	40	140
БНХАУ	110	50	160
Япон	200	60	260
7. Газар дундын болон Өмнөд Африкийн орнууд			
Алжир	100	40	140
Грек	100	40	140
Египет	100	40	140
Ирак	100	40	140
Иран	100	40	140
Израиль	160	50	210
Кипр	120	40	160
Мавритан	100	40	140
8. Азийн хөгжиж буй болон буурай хөгжилтэй орнууд			
Вьетнам	100	30	130
Афганистан	80	30	110
Бирм	100	30	130
Балба	80	30	110
Бангладеш	80	30	110
Лаос	80	30	110

Тайлбар: Хавсралтад нэр заагдаагүй орны хувьд гадаад албан томилолтын зардлыг тухайн орны харьяалагдах бүсэд багтах орны жишгээр тооцно.